

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 9/410/8/165

Улаанбаатар хот

Халдвартай материал, оношилгооны сорьц,
биобэлдмэл тээвэрлэх журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24-р зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 45.3 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Халдвартай материал, оношилгооны сорьц, биобэлдмэл тээвэрлэх журам"-ыг нэгдүгээр, хүн ба мал амьтанд өвчин үүсгэх А категорид хамарагдах халдвартай материалуудын жагсаалтыг хоёрдугаар, халдвартай материал оношилгооны сорьц, биобэлдмэл тээвэрлэхэд дагалдах хуудсыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, Зоонозын өвчин судлалын үндэсний төв /Н.Цогбадрах/, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал болон агаарын тээвэрлэгч, автотээврийн, төмөр замын байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /С.Батболд./-д тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү журам гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/93 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Эрүүл мэнд, Зам, тээврийн
хөгжлийн сайдын 2020 оны
11.10.2020 тоот тушаалын
нэгдүгээр хавсралт

ХАЛДВАРТАЙ МАТЕРИАЛ, ОНОШИЛГООНЫ СОРЬЦ,
БИОБЭЛДМЭЛ ТЭЭВЭРЛЭХ ЖУРАМ

3020050420 5019487 СВА7589

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журам нь Монгол улсын хэмжээнд халдвартай материал, оношилгооны сорьц, биобэлдмэл тээвэрлэх, хилээр оруулах, гаргах үйл ажиллагаа, харилцааг зохицуулна.

1.2 Энэ журмыг Монгол улсын нутаг дэвсгэрт холбогдох байгууллагууд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мөрдөнө.

1.3 Аймгаас хот хооронд халдвартай материал, оношилгооны сорьц, биобэлдмэл (цаашид Ачаа гэх)-ийг агаарын тээвэрлэгч, төмөр зам, автотээврийн байгууллагууд, шуудангийн компаниуд (цаашид Тээвэрлэгч гэх) ба Эрүүл мэндийн байгууллагууд (цаашид Илгээгч, Хүлээн авагч гэх)-ын хооронд байгуулсан ачаа тээвэрлэх гэрээг үндэслэн тээвэрлэнэ.

1.4 Ачаа тээвэрлэхтэй холбоотой гарах зардлыг гэрээнд заасны дагуу зохицуулна.

1.5 Ачаа яаралтай хүргэх зорилгоор буухиа зэрэглэлийн шуудангаар илгээж болно.

1.6 Тээвэрлэлтийн үнэ тарифыг тээвэрлэгч байгууллага тогтоосон байна.

1.7 Халдвартай материал, оношилгооны сорьцыг хилийн чанадад илгээхдээ Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (WHO), Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллага (OIE)-аас гаргасан “Халдвартай материал болон оношилгооны дээжүүдийг аюулгүй тээвэрлэх удирдамж”, Дэлхийн шуудан холбооны конвенци (UPU), Иргэний нисэхийн олон улсын байгууллагаас гаргасан “Аюултай ачааг агаараар аюулгүй тээвэрлэх техникийн зааварчилгaa”, Олон улсын агаарын тээврийн холбоо (IATA-International Air Transport Association)-ноос гаргасан “Аюултай ачааны дүрэм” (DGR)-ийн шаардлагыг баримтална.

1.8 Тус журам нь Монгол улсын “Эрүүл мэндийн тухай”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай”, “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай”, “Иргэний нисэхийн тухай хууль”, “Шуудангийн тухай”, “Автотээврийн тухай”, “Амьтан, ургамал, тэдгээрийн түүхий эд, бүтээгдэхүүнийг хилээр нэвтрэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай” хуулиуд, Дэлхийн шуудан холбооны конвенциуд, бусад холбогдох эрх зүйн баримт бичигт нийцнэ.

1.9 Журмын хэрэгжилтийг хууль хяналтын байгууллага, аймаг, нийслэл, орон нутгийн Засаг даргын тамгын газар, шуудангийн үндэсний сүлжээ эзэмшигч зэрэг байгууллагууд хариуцан зохион байгуулна.

1.10 Ачааны тээвэрлэлт, бүрэн бүтэн байдал, нууцлалыг илгээгч, тээвэрлэгч, хяналтын байгууллагууд хариуцна.

1.11 Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд үүсэх аливаа зөрчил, маргааныг 1.8-д зааснаас гадна бусад хууль тогтоомж, хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэнэ.

Нэр, томъёоны тодорхойлолт

Журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.

“Ачаа” гэж илгээгчээс хаягласан хүлээн авагчид хүргүүлэхээр хүн, мал амьтанд өвчин үүсгэгч бичил биетнийг агуулсан дээж материал, омог, хор, генетикийн материалыг ачааны хэлбэрээр тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн биет зүйлийг хэлнэ.

“Биобэлдмэл” гэж хүний болон мал амьтны өвчнийг эмчлэх, оношлох, урьдчилан сэргийлэх зориулалтаар амьд бие, эд эсээс үйлдвэрлэлийн онцгой нөхцөлд гаргаж авсан вакцин бусад бүтээгдэхүүнийг хэлнэ.

“Гуравласан савлалт” гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагаас гаргасан “Халдвартай зүйлс болон оношилгооны дээжүүдийг аюулгүй тээвэрлэх удирдамж”, Олон улсын савлалтын зааварчилгааны 620, 650 дугаар шаардлагыг хангасан баглаа боодлыг хэлнэ.

“Халдвартай материал” гэдэг нь өвчний үүсгэгчийг (Pathogens) агуулж байгаа нь мэдэгдэж байгаа болон байх үндэслэлтэй гэж үзэж буй эдийг хэлнэ.

Халдвартай материалуудыг 2 категориид хуваадаг.

“А категориид хамарагдах халдвартай материал” гэж тээвэрлэлтийн явцад ил гарсан тохиолдолд эрүүл хүн, амьтныг бүрэн зэрэмдэг болгох, эсхүл амь насанд нь аюул учруулах, үхэлд хүргэх чадвар бүхий бодисыг хэлнэ.

- Хүнд өвчлөл үүсгэдэг халдвартай материалуудыг UN 2814 гэсэн дугаараар тэмдэглэнэ.
- Зөвхөн амьтанд өвчлөл үүсгэдэг халдвартай материалуудыг UN 2900 гэсэн дугаараар тэмдэглэнэ.

“Халдвартай материалуудыг 2 категори B-д хамарагдах материалууд” - категори “B”-д орох шалгуур үзүүлэлтүүдийг хангагүй халдвартай материалууд UN3373 гэсэн дугаараар тэмдэглэгдэнэ.

“Өсгөвөр” - Өвчин үүсгэгчийг лабораторийн тусгай аргаар цэврээр гаргаж авсныг хэлнэ.

“Оношилгооны сорьц” - Хүнээс авсан бүх төрлийн сорьцыг хэлнэ. Энэ нь судалгаа, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн зорилгоор авсан цус, шүүрэл, ялгадас, арчдас ба түүний бүрдлүүд, биологийн шингэн, эд эс, чанарын хяналтын материал зэрэг байна.

Хоёр. Ачаа илгээгчийн үүрэг, хариуцлага

2.1 Төрийн захиргааны төв байгууллага, олон улсын болон хууль хяналтын байгууллагаас баталсан хууль, дүрэм, журмын дагуу ачааг тээвэрлэгчид хүлээлгэн өгөх хүртэлх арга хэмжээг илгээгч хариуцан гүйцэтгэнэ.

2.2 Илгээгч нь халдвартай материал, оношилгооны сорьц, биобэлдмэл агуулсан ачааг тээвэрлэгчид хүлээлгэн өгөхдөө НҮБ-ын сав баглаа боодлын зөвлөмж, тээвэрлэгчийн дагаж мөрдөж байгаа дүрэм, журмыг баримтална.

2.3 Ачааг тээвэрлэх явцад ачааны бүрэн бүтэн байдал, чанар нь алдагдахгүй байх нөхцөлийг ханган сав баглаа, боодлыг сайтар шалган ачааг холбогдох стандарт, техникийн нөхцөлийн дагуу тээвэрлэлтэд урьдчилан бэлтгэнэ.

2.4 Илгээгч нь хүлээн авагч байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллана.

2.5 Илгээгч нь тээвэрлэгч байгууллагад урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр ачааг хүлээлгэн өгнө.

2.6 Илгээгч нь халдвартай материал, оношилгооны сорьцтой халдвар хамгаалын дүрмийг баримтлан ажиллана.

2.7 Илгээгч нь ачааны ангилал, аюулын зэрэглэл, ачаа илгээгч, хүлээн авагчийн талаарх мэдээллээр тээвэрлэгчийг хангаж, шаардлагатай баримтуудыг бүрдүүлэн тээвэрлэгчид өгнө.

2.8 Хилийн чанд руу илгээх тохиолдолд илгээгч нь зохих бичиг баримтыг бүрдүүлэн, халдвартай материал, оношилгооны сорьц, чанарын хяналтын материалыг гаргах экспортын зөвшөөрөл авна.

2.9 Энэ журмын 5 дугаар зүйлд заасан шаардлагуудыг илгээгч заавал хангасан байна.

2.10 Халдвартай материал, оношилгооны сорьцыг тээвэрлэгч байгууллагуудад хүлээлгэн өгөхөөс өмнө уг илгээмжийн биоаюулгүй байдал, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтыг илгээгч байгууллагууд хариуцна.

2.11 Ачаа илгээгч нь тээвэрлэгч байгууллагатай хамтран ажиллагсдад сургалт зохион байгуулж, эрсдэлээс сэргийлэх мэдлэг олгосон байна.

2.12 Ачаа илгээгч нь А ангилалын UN 2900, UN 2814 дугаартай халдвартай материал, оношилгооны сорьцыг ОУ-ын Агаарын Тээвэрлэгчийн Холбооны “Аюултай ачааны дүрэм”-ийг зөрчиж тээвэрлүүлсэн бол хуулийн хариуцлага хүлээнэ.

2.13 Ачаа илгээгч нь тухайн халдвартай материал, оношилгооны сорьц нь агаараар тээвэрлэхэд хориглогдоогүй гэдгийг баталгаажуулна.

2.14 Ачаа илгээгч нь ачааг орон нутгийн нисэх болон төмөр замын буудал дээр 1 цагийн өмнө ирж хариуцсан албан тушаалтанд хүлээлгэж өгнө.

Гурав. Тээвэрлэгчийн үүрэг, хариуцлага

3.1 Тээвэрлэгч нь илгээгдэж буй ачааг нислэг болон аялалаас өмнө шалгах хуудсаар хүлээн авч, аялал эхлэх хүртэл ачааны бүрэн бүтэн байдлыг хариуцан хадгалж, бүх төрлийн тээврийн хэрэгсэлд (агаарын хөлөг)-т аюулгүйгээр ачижж байрлуулна.

3.2 Тээвэрлэгч нь орон нутгаас /аймаг, алслагдсан дүүргээс/ илгээгдэж буй ачааг төмөр зам, автомшинаар тээвэрлэхдээ аюулгүй байдлыг хангасан хэсэгт байрлуулж, аялалын явцад хариуцах албан тушаалтанг томилон хүлээлгэн өгнө.

3.3 Ачаа илгээгчээс ирсэн ачааг орон нутгийн нисэх болон төмөр замын буудал дээр 1 цагийн өмнө ирж хүлээн авна.

3.4 Ачаа хүлээн авагчид агаарын хөлөг буух цагийг урьдчилан мэдэгдэнэ.

3.5 Нислэг saatсан тохиолдолд ачааг хариуцаж байгаа хүнд мэдэгдэж, илгээгчээс өгсөн заавар, хадгалалтын горимыг баримтлан дараагийн нислэг хүртэл хадгална.

3.6 Тээвэрлэлттэй холбоотой зааварчилгаа, баримт бичгүүдийг бөглөж илгээгчид өгнө.

3.7 Ачааг шуурхай, аюулгүй байдлыг хангасан маршрутаар тээвэрлэх талаар илгээгчтэй зөвшилцөн, баталгаа өгнө.

3.8 Ачааг тээвэрлэгч байгууллагын ажиллагсад нь тээвэрлэх халдвартай материалын нэр төрөл, ангиллаас хамаарч тээвэрлэлтийн явцад баримтлах дүрэм, журам, халдвартай материал алдагдсан тохиолдолд өөрийгөө болон бусдыг халдварын эрсдлээс хамгаалах чиглэлээр сургалтад хамрагдсан байна.

3.9 Тээвэрлэгч нь зам тээврийн болон түүнтэй адилтгах бусад осол аюулын үед Замын хөдөлгөөний дүрэм, Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрмийн заалтыг баримталж, илгээгчид энэ тухай мэдэгдэх, ослын аюултай талбайг тэмдэглэн зааглаж гадны хүмүүсийг эрсдэлээс хамгаалах, цагдаа, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ирэх үед тээж яваа ачааны хор хөнөөлийн талаар таниулах үүргийг хүлээнэ.

3.10 Тээвэрлэгч нь ачаа гэмтсэний улмаас цус биологийн шингэн асгарах үед авах арга хэмжээний цомог (шингэн шингээх материал, хлор агуулсан халдвартайжүүлэх уусмалыг шүршигчийн хамт, гоожихоос хамгаалсан уут, ариутгасан амны хаалт, резинэн бээлий, ус нэвтэрдэггүй цаас), галын хор зэргийг бэлэн байлгана.

3.11 Тээвэрлэгч нь энэхүү журмын 2.7 болон 2.10-д заасан шаардлагыг ачаа илгээгч биелүүлээгүй тохиолдолд халдвартай материал, оношилгооны сорьцыг тээвэрлэхгүй байх эрхтэй.

3.12 Давагдашгүй хүчин зүйл болох цаг уураас шалтгаалсан хариуцлагыг тээвэрлэгч хүлээхгүй.

3.13 Ачаа хүлээн авагч нь ачаагаа цагтаа аваагүйгээс болсон эрсдэлийг тээвэрлэгч хүлээхгүй.

Дөрөв. Шинжилгээний сорьцыг хүлээн авах, шинжилгээг хийх
эрүүл мэндийн байгууллагын үүрэг, хариуцлага

4.1 Шинжилгээний сорьц хүлээн авах байгууллага нь тухайн сорьц илгээж буй байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулна.

4.2 Сорьц илгээхтэй холбоотой шаардлагатай мэдээлэл, бичиг баримтыг чирэгдэлгүй гарган өгнө.

4.3 Шинжилгээний сорьцыг хүлээн авах эрүүл мэндийн байгууллага нь илгээж буй сорьцыг хүлээн авах ажилтны албан тушаал, нэр, утасны дугаар болон сорьц хүлээн авах цагийн хуваарийг илгээгчид урьдчилан мэдэгдсэн байна.

4.4. Сорьцыг хүлээн авах хариуцсан албан тушаалтан нисэх, төмөр замын буудал дээр бичиг баримттай ирж, өөрийн биеээр хүлээн авна.

4.4 Шинжилгээний сорьцыг хүлээн авахдаа тээвэрлэлтийн нөхцөл, битүүмжлэл, сорьцын бүрэн бүтэн байдал, сорьцын хэмжээ, чанар, дагалдах бичиг баримтын бүрдлийг шалган, хүлээн авсан тухай тэмдэглэл хөтөлнө.

4.5 Шинжилгээний сорьц асгарсан, бүрэн бүтэн байдал алдагдсан, шаардлага хангахгүй тохиолдолд тэмдэглэл хийн, сорьц илгээсэн эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэнэ.

4.6 Сорьц шаардлага хангаагүй тохиолдолд шинжилгээ хийхгүй байх эрхтэй.

4.7 Эрүүл мэндийн байгууллага нь илгээсэн сорьцыг шинжлэх, онош тодруулах, баталгаажуулах, лавлагаа шинжилгээ хийнэ.

4.8 Эрүүл мэндийн байгууллага нь шинжилгээний үр дүнг сорьц илгээгч байгууллага руу цахимаар илгээнэ.

4.9 Цахимаар хариу илгээсэн тухай мэдээллийг сорьц илгээгч байгууллага; утсаар давхар мэдэгдэнэ.

Тав. Халдвартай материал, оношилгооны сорьц
тээвэрлэхэд тавигдах шаардлагууд


5.1 Аюулгүй тээвэрлэлтийн нөхцөл нь олон улсын тээвэрлэлтийн адил бөгөөд савлалт нь хаяж гээгдэхээр гүйгээр тээвэрлэлтийн зөв горимыг хангасан байна.

5.2 Ачааг тээвэрлэлтийн шаардлага хангасан гуравласан сав баглаа боодлоор савлан тээвэрлэгчид хүлээлгэн өгнө. Гуравласан савлалтын загварыг Зураг 2-с харна уу. Үүнд:

1. Анхдагч сав-Сорьц агуулсан анхдагч сав нь ус нэвтрүүлдэггүй, нэвчдэггүй байна. Энэ сав нь эвдэрсэн тохиолдолд бүх шингэнийг шингээх хангалттай хэмжээний шингээгч материалыар ороосон байна.
2. Хоёрдогч сав нь бат бөх, ус нэвтрүүлэхгүй, нэвчдэггүй анхдагч савыг бэхлэх, хамгаалах зориулалттай. Хэд хэдэн ороож багласан анхдагч савыг хоёрдогч саванд хийж болно. Олон тооны савыг зөвлөхийн тулд нэмэлт шингээгч материалыар тус тусад нь ороож ашиглах шаардлагатай.
3. Гаднах хайрцаг. Хоёрдогч савыг зөөвөрлөх явцад гэмтэл, ус гэх мэт гадны нөлөөллөөс хамгаалдаг хатуу хайрцагт байрлуулна.


5.3 Илгээгч нь халдвартай материал, оношилгооны сорьц, биобэлдмэлийг ялгах зорилгоор илгээмжийн тухай мэдээлэл бүхий таних тэмдгүүд болон бусад мэдээллийг гуравдугаар савны гадна талд наасан байна.

5.4 Тээвэрлэгдэх халдвартай материал, оношилгооны сорьцын халдварын аюулын зэрэг, тээвэрлэлтийн онцлог (температур, хагарч гэмтэх, чийг уснаас хамгаалах)-ийг харуулсан тусгай тэмдэг (биоаюулгүйн тэмдэг) (зураг 1) зэргийг ховхорч унахааргүй наасан байна.



Зураг 1. БИОЛОГИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, КАТЕГОРИ В-Д АШИГЛАХ САВ, БАГЛАА БООДЛЫН ТЭМДЭГЛЭГЭЭ (PACKING INSTRUCTION P650 (CATEGORY B))

5.5 Гуравласан савлалтын системийг нэмэлт тодорхойлолт, шошгын шаардлагуудын хамт хэрэглэнэ. Эхний сав буюу сорьц агуулсан савны багтаамж дээд тал нь 50 мл эсхүл 50 г байх ба нийт багтаамж нь шингэн зүйл бол 4 л –ээс, хатуу материал бол 4 кг-с ихгүй (гаднах боолтын доторх багтаамж) байна.



Зураг 2. БИОЛОГИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, КАТЕГОРИ А-Д АШИГЛАХ САВ, БАГЛАА БООДЛЫН ТЭМДЭГЛЭГЭЭ (PACKING INSTRUCTION P620 (CATEGORY A))

5.6 Тээвэрлэх биоаюултай ачааны гаднах шошго, тэмдэглээ нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- Илгээгч байгууллага, хүний нэр, хаяг, утасны дугаар
- Хүлээн авагч байгууллага, хүний нэр, хаяг, утасны дугаар


- Осол, зөрчлийн үед яаралтай холбоо барих эрх бүхий байгууллага, ажилтны нэр, хаяг, утасны дугаар
- Ачааны оноосон нэр
- НҮБ-ын сав баглаа боодлын тусгай тэмдэглэгээ
- Огноо

5.7 Тээвэрлэгчийн мэдвэл зохих тээвэрлэлтэнд шаардлагатай баримт бичгийг гадна талын баглаа боодол дээр наасан байна.

5.8 Баглаа боодол нь дотор агуулагдах зүйлийг ямарч тохиолдолд гадагшаа алдагдахгүй байх, тээвэрлэлтийн жирийн нөхцөлд төдийгүй доргилт, температур, чийг, даралтын өөрчлөлтөөс сэргийлж чадахуйц байхаар аюулгүй байдлыг илгээгч тал хангасан байна.

5.9 Сорьц агуулсан 1-р сав болон хоёрдогч савлалт нь 95кРа-дотоод даралтад тэсвэртэй байх ёстой.

5.10 Сав баглаа боодлын чиглэл заасан (зураг 3) шошгыг гадна савны 2 талд босоо байрлалд тээвэрлэхээр наасан байна.



Зураг 3. Сав баглаа боодлын чиглэл заасан шошго

5.11 А ангиллын UN 2814 болон UN 2900 дугаартай халдвартай материалыг савлалтын зааварчилгаа 620 –д нийцүүлэн савлаж тээвэрлэнэ.

5.12 Б ангилалын UN3373 дугаартай материалыг савлалтын зааварчилгаа 650-д нийцүүлэн савлаж тээвэрлэнэ.

5.13 Халдвартай материал тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг цэвэрлэх шаардлагатай тохиолдолд ариутгал хийнэ.

Зургаа. Онцлох заалтууд

6.1 Аюул багатай, аюултай ачааны шаардлагад тохирохгүй дараах материалыуд байдаг. Үүнд:

- Хүн амьтанд өвчлөл үүсгэхгүй, халдварын эрсдэл байхгүй материал
- Хүн амьтанд эмгэг төрүүлдэггүй үүсгэгчүүд ба хүний эрүүл мэндэд аюулгүй болгосон идэвхигүйжсэн микроорганизмууд
- Халдварын эх уурхай байж болзошгүй хүрээлэн байгаа орчноос авсан сорьцууд (хүнсний бүтээгдэхүүн ба усны сорьцууд)
- Цус сэлбэх болон шилжүүлэх зорилгоор тээвэрлэж буй цус, цусан бүтээгдэхүүн
- Оношилгооны зорилгоор авсан цусны сорьц ба цусны хатаасан наацууд
- Эмнэлэгт болон эмчилгээнд хэрэглэгдэх ариутгагдсан материалыуд

6.2 Энэ журмын 6.1-д заасан заалтад орох эсэхийг илгээгч байгууллагын мэргэжилтэн тодорхойлно. Мэргэжилтэн нь тухайн газар нутаг дахь халдвартын нөхцөл хүн, амьтан тус бүрийн хувийн онцлог, өвчний шинж тэмдэг, өвчний түүх зэрэг мэдээллүүдийг үндэс болгоно.

Эрүүл мэнд, Зам, тээврийн
хөгжлийн сайдын 2020 оны
~~9/9/2020~~ тоот тушаалын
хоёрдугаар хавсралт

**Хүн ба мал амьтанд өвчин үүсгэх категори А-д
хамарагдах халдвартай материалуудын жагсаалт**

НҮБ-ЫН ДУГААР БОЛОН
АЧААНЫ ОНООСОН НЭР

Б.13467 СБА7589

Бичил биет

| | |
|---|---|
| НҮБ-ЫН ДУГААР БОЛОН АЧААНЫ ОНООСОН НЭР | Бичил биет |
| Хүнд өвчлөл үүсгэдэг материалууд | <ul style="list-style-type: none"> - Bacillus anthracis (зөвхөн өсгөвөр) - Brucella abortus (зөвхөн өсгөвөр) - Brucella melitensis (зөвхөн өсгөвөр) - Brucella suis (зөвхөн өсгөвөр) - Burkholderia mallei-Pseudomonas mallei-glanders (зөвхөн өсгөвөр) - Burkholderia pseudomallei-Pseudomonas pseudomallei (зөвхөн өсгөвөр) - Chlamydia psittaci-avian strains (зөвхөн өсгөвөр) - Clostridium botulinum (зөвхөн өсгөвөр) - Coccidioides immitis (зөвхөн өсгөвөр) - Coxiella burnetii (зөвхөн өсгөвөр) - Grimean-Congo haemorrhagic fever virus - Denque virus (зөвхөн өсгөвөр) - Eastern equine encephalitis virus (зөвхөн өсгөвөр) - Escherichia coli, verotoxigenic (зөвхөн өсгөвөр) - Ebola virus - Flexal virus - Francisella tularensis (зөвхөн өсгөвөр) - Guanarito virus - Hantaan virus - Hantaviruses causing haemorrhagic fever with renal syndrome - Hendra virus - Hepatitis B virus (зөвхөн өсгөвөр) - Herpes B virus (зөвхөн өсгөвөр) - Human immunodeficiency virus (зөвхөн өсгөвөр) - Highly pathogenic avian influenza virus (зөвхөн өсгөвөр) - Japanese encephalitis virus (зөвхөн өсгөвөр) - Junin virus - Kyasanur Forest disease virus - Lassa virus - Machupo virus - Marburg virus - Monkeypox virus - Mycobacterium tuberculosis (зөвхөн өсгөвөр) - Nipah virus - Omsk haemorrhagic fever virus - Poliovirus (зөвхөн өсгөвөр) - Rabies virus (агаарын тээвэрт 2005 оноос "зөвхөн өсгөвөр" гэсэн нэмэлт оруулсан) - Rickettsia prowazekii (зөвхөн өсгөвөр) - Rickettsia ricettsii (зөвхөн өсгөвөр) - Rift Valley fever virus (агаарын тээвэрт 2005 оноос "зөвхөн өсгөвөр" гэсэн нэмэлт оруулсан) - Russian spring-summer encephalitis virus (зөвхөн өсгөвөр) - Sabia virus - Shigella dysenteriae type 1 (зөвхөн өсгөвөр) |

| | |
|--|--|
| | <ul style="list-style-type: none"> - Tick-borne encephalitis virus (зөвхөн өсгөвөр) - Variola virus - Venezuelan equine encephalitis virus(агаарын тээвэрт 2005 оноос “зөвхөн өсгөвөр”гэсэн нэмэлт оруулсан) - West Nile virus(зөвхөн өсгөвөр) - Yellow fever virus(зөвхөн өсгөвөр) - Yersinia pestis virus(зөвхөн өсгөвөр) |
| UN2900 Зөвхөн амьтанд нөлөөлөх халдвартай материалууд | <ul style="list-style-type: none"> - African horse sickness virus(агаарын тээвэрт 2005 оноос хасагдсан) - African swine fever virus(агаарын тээвэрт 2005 оноос “зөвхөн өсгөвөр”гэсэн нэмэлт оруулсан) - Avian influenza virus Type 1(агаарын тээвэрт 2005 оноос “Velogenic”гэсэн нэмэлт оруулсан) - Newcastle disease virus(агаарын тээвэрт 2005 оноос “зөвхөн өсгөвөр”гэсэн нэмэлт оруулсан) - Bluetongue virus(агаарын тээвэрт 2005 оноос хасагдсан) - Classical swine fever virus(агаарын тээвэрт 2005 оноос “зөвхөн өсгөвөр”гэсэн нэмэлт оруулсан) Foot and mouth disease virus(агаарын тээвэрт 2005 оноос “зөвхөн өсгөвөр”гэсэн нэмэлт оруулсан) - Lumpy skin disease virus(агаарын тээвэрт 2005 оноос “зөвхөн өсгөвөр”гэсэн нэмэлт оруулсан) - Mycoplasma mycoides-contagious bovine pleuropneumonia(агаарын тээвэрт 2005 оноос “зөвхөн өсгөвөр”гэсэн нэмэлт оруулсан) - Peste des petits ruminants virus(агаарын тээвэрт 2005 оноос “зөвхөн өсгөвөр”гэсэн нэмэлт оруулсан) - Rinderpest virus(агаарын тээвэрт 2005 оноос “зөвхөн өсгөвөр”гэсэн нэмэлт оруулсан) - Sheep-pox virus(агаарын тээвэрт 2005 оноос “зөвхөн өсгөвөр”гэсэн нэмэлт оруулсан) - Goat-pox virus(агаарын тээвэрт 2005 оноос “зөвхөн өсгөвөр”гэсэн нэмэлт оруулсан) - Swine vesicular disease virus(агаарын тээвэрт 2005 оноос “зөвхөн өсгөвөр”гэсэн нэмэлт оруулсан) - Vesicular stomatitis virus(агаарын тээвэрт 2005 оноос “зөвхөн өсгөвөр”гэсэн нэмэлт оруулсан) |

ХАЛДВАРТАЙ МАТЕРИАЛ, ОНОШИЛГООНЫ СОРЬЦ,
БИОБЭЛДМЭЛ ТЭЭВЭРЛЭХЭД ДАГАЛДАХ ХУУДАС

Эрүүл мэнд, Зам, тээврийн
хөгжлийн сайдын 2020 оны
10.10.19/16 тоот тушаалын
туравдугаар хавсралт

9020050420 5919487 СЫА7589

| | | | | |
|---|---|---|---|---|
| Баримтын № | | Категори A <input type="checkbox"/> UN дугаар | | |
| ХЭНЭС (Илгээгч бөглөнө) | | ХЭНД (Илгээгч бөглөнө) | | |
| Огноо/...../..... | Байгууллагын нэр /утасны дугаар//..... | Албан хаагчийн нэр /утасны дугаар//..... | Байгууллагын нэр /утасны дугаар//..... | Албан хаагчийн нэр /утасны дугаар//..... |
| Цаг, минут/..... | Байгууллагын хаяг/..... | Албан тушаал/..... | Байгууллагын хаяг/..... | Албан тушаал/..... |
| Сорьцын нэр 1..... 2..... 3..... 4..... | | Тээвэрлэх горим/..... | | |
| Тээвэрлэлтийн зардал (₹)/..... | | Тээвэрлэлийн зардлыг төлсөн байдал 1. Бэлнээр <input type="checkbox"/> 2. Нэхэмжлэхээр <input type="checkbox"/> | | |
| Тээвэрлэлтийн зардлыг хариуцсан байгууллагын нэр | | Дагалдах баримт бичиг | | |
| Илгээгчийн гарын үсэг | | Тээвэрлэгчийн гарын үсэг | | |
| Хүлээн авсан тухай мэдээлэл (Хүлээн авагч бөглөнө) | | | | |
| Огноо/...../..... | Албан хаагчийн нэр /утасны дугаар//..... | Ачааны бүрэн бүтэн байдал Алдагдсан <input type="checkbox"/> Алдагдаагүй <input type="checkbox"/> | Тээвэрлэлтийн горим хангагдсан байдал ТИЙМ <input type="checkbox"/> ҮГҮЙ <input type="checkbox"/> | Тайлбар |
| Цаг, минут/..... | Албан тушаал/..... | | | |
| Хүлээн авагчийн гарын үсэг, нэр /...../..... | | Хүлээлгэн өгсөн хүний гарын үсэг, нэр /...../..... | | |